

## МОНГОЛЫН ХҮН АМЫН НАС ХҮЙСИЙН БҮТЦИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БА ИРЭЭДҮЙН ХАНДЛАГА

Монгол Улсын Их Сургууль, Хүн Амын  
Сургалт судалгааны төв  
Рикардо Ньюперт

*Хүн амын судалгааны нэг чухал хэсэг нь хүн амын нас, хүйсийн бүтцийн судалгаа байдаг. Хүн амын нас, хүйсийн бүтцийг судлах нь нэг талаар бизнес, эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд зэрэг салбарт шаардлагатай бодлого боловсруулах, төлөвлөлт хийх, нөгөө талаар хүн ам зүйн хүчин зүйлсийг нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөвлөлтөнд тусгахад ихээхэн ач холбогдолтой юм.*

*Энэхүү ажлаар Монгол Улсын хүн амын нас, хүйсийн бүтцийн өнгөрсөн, одоо, ирээдүйн өөрчлөлт, чиг хандлагыг авч үзэж, энэ талаар сонирхолтой хэлэлцүүлэг өрнүүлж, дүгнэлт хийсэн байна. Мөн хүн амын нас, хүйсийн бүтцийг харуулахуйц зарим үзүүлэлтийг тооцсон ба хүн амын моментумыг судалж, Монгол Улсын хүн ам моментумаараа өсөх хандлагын талаар хэтийн тооцоо хийсэн нь нэлээд шинэлэг, ач холбогдолтой зүйл болжээ.*

*Түүнчлэн хүн амын төрөлт буурч, улмаар хүн амын өсөлтийн бууралт ажиглагдаж байгаа энэ үед хүн амын өсөлтийн талаарх судалгаа, шинжилгээний ажил хийж буй хүмүүст ашиглаж болохуйц бодит баримт, суурь материал болох юм.*

### Удиртгал

Хүн ам зүйн судалгаанд хүн амын нас, хүйсийн бүтцийг судлах нь хүн ам, нийгэм, эдийн засгийн бодлого боловсруулах, хүн амын хүчин зүйлсийг нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинжилгээнд тусгахад чухал ач холбогдолтой. Хүн амын нас, хүйсийн байдал нь нийгэм, эдийн засаг, соёлын асуудлуудтай нягт холбоотой учраас түүнийг шинжлэх шаардлагатай байдаг. Тухайлбал, сургуульд хамрагдалт, ажиллах хүчний нөөц, гэрлэх, төрөх, шилжих гэх мэт. Түүнчлэн зарим нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээ нь нас хүйсийн бүтцээс хамааран өөр өөр байдаг. Нас хүйсийн бүтцийн мэдээлэл нь нийгмийн чиг хандлагыг тайлбарлах, зах зээлийг тодорхойлох, ирээдүйн төлөвлөлт хийхэд чухал ач холбогдолтой. Мөн нийгмийн мөн чанар, функцийг ойлгоход чухал байдаг (Rowland.D.T, 2003). Үүний зэрэгцээгээр хүн амын түүхэн хөгжил хувьслыг болон ирээдүйн хэтийн төлвийг тодорхойлно.

Хүн амын бүтэц нь хүн амын өсөлт, өөрчлөлтийн бүрэлдэхүүн хэсгүүд болох төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөнөөс хамаардаг билээ. Төрөлт, нас баралтын өндөр түвшин нь хүн ам залуужих үндэс болдог. Энэ нь хүүхэд болон залуучуудын эзлэх хувийн жин өндөр байна гэсэн үг юм. Төрөлт, нас баралт буурахын хэрээр хүн ам насжиж, насанд хүрсэн залуу, дунд болон ахимаг насны хүмүүсийн эзлэх хувийн жин өсдөг. Шилжин ирэх хөдөлгөөн нэмэгдсэнээр насанд хүрсэн залуу эрэгтэйчүүдийн (эмэгтэйчүүдийн) хувийн жин эрс нэмэгдэхэд хүргэдэг. Түүнчлэн дайн, улс төрийн тогтворгүй байдал, эдийн засгийн хямрал гэх мэт гэнэтийн үзэгдлийн үр дүнд зарим насны бүлгийн хүмүүсийн хувь багасна. Үүнийг тухайн үеийн төрөлтийн бууралт, нас баралтын өсөлт зэргээр тайлбарладаг.





Цаашилбал, хүн амын бүтэц нь бидэнд хүн амын ирээдүйн шинж байдлын талаар үнэтэй мэдээллийг өгнө. Жишээ нь, залуу насны бүтэцтэй хүн амын хувьд нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн хувийн жин өндөр байдаг учраас хүн амын хурдацтай өсөх боломж бүрддэг. Түүнчлэн энэхүү байдал нь боловсрол болон ажил эрхлэлтийн салбарт хөрөнгө оруулалтыг тодорхой хугацаанд нэмэгдүүлэхийг шаардана. Нөгөөтэйгүүр, хүн ам насжихын хэрээр тэтгэвэр, эрүүл мэндийн үйлчилгээний санхүүжилт болон ажиллах хүчний нийлүүлэлтийн бууралтын асуудлуудад анхаарах хэрэгтэй болдог.

Энэхүү ажлын зорилго нь Монголын хүн, амын нас хүйсийн бүтцийг судлах явдал юм. Үүний зэрэгцээ хүн амын бүтэцтэй холбоотой зарим сэдвүүдийг энд хөндөх болно. Тухайлбал, хүн амын моментум, зорилтот насны бүлгийнхний өсөлтийн ялгаатай байдал зэргийг судлах юм. Мөн Монголын хүн амын хүн ам зүйн шинж байдлын талаарх цогц шинжилгээг хүн ам зүйч, эдийн засагч, нийгэм судлаачдад болон бодлого боловсруулагчдад хүргэхийг зорьсон. Судалгаанд Үндэсний Статистикийн Газрын 1969, 1979, 1989, 2000 оны тооллого (ҮСГ, 1994; 2001) болон хүн амын хэтийн тооцоог ашиглав (ҮСГ, 2002).

### **Монголын хүн амын бүтцийн өөрчлөлт**

Хүн амын нас, хүйсийн бүтцийг хүн амын суваргаар харуулах нь хамгийн тохиромжтой арга юм. Энэ нь насны бүлэг бүр дэх эрэгтэй, эмэгтэй хүн амыг хувийн жин буюу тоогоор харуулдаг хэвтээ байрлалтай тэгш өнцөгт дүрслэл юм. Суурь хэсэгт залуу насны бүлгийн хүн амыг, зүүн гар талд эрэгтэй хүн ам, баруун гарт эмэгтэй хүн амыг байрлуулах зарчимтай. Хүн амын насны бүтцээс хамааран суварга нь өөр өөр хэлбэртэй байж болно. Жишээлбэл, залуу бүтэцтэй хүн амын хувьд суварга пирамид хэлбэртэй, харин хүн ам насжих тутам суварга тэгш өнцөгт хэлбэрт дөхөж очно. Шилжих хөдөлгөөн болон гэнэтийн үзэгдэл, үйл явцаас хамааран суваргын хэлбэр гажуудаж болох талтай (PRB, 2000).

Зураг 1а-аас 1г-д Монгол Улсын 1969, 1979, 1989, 2000 хүн амын суваргыг дүрслэн харууллаа. Суваргыг хувийн жингээр бус, тоогоор зурсан бөгөөд үүнээс хүн амын бүтэц бүрэлдэхүүнийг төдийгүй, хүн амын хэмжээний өөрчлөлтийг харж болно. Зургаас харахад Монгол Улсын хүн амын бүтэц бүрэлдэхүүн нэлээд өөрчлөгджээ. Хүн ам ерөнхийдөө залуу насны бүтэцтэй байснаа завсрын гэж хэлж болохоор бүтцэд шилжсэн байна. Ялангуяа 1989 ба 2000 оны хооронд хүн амын нас, хүйсийн бүтэц нэлээд өөрчлөгдсөн байна. 2000 оны хүн амын суваргыг харвал 0-4 болон 5-9 насны хүн амын тоо 10-14 насны хүн амын тооноос бага байна. 1989 оны тооллогоор 0-9 насны хүн амын хувийн жин 29.6 байснаа 2000 он гэхэд 20.7 хувь болж буурчээ. Энэхүү байдал нь хүн амын төрөлтийн түвшин ихээхэн буурч, хүн ам хөгшрөх хандлагатай болж байгаа буюу хүүхэд залуучуудын хувийн жин буурч, насанд хүрэгсэд буюу хөгшин хүмүүсийн хувийн жин өсөж байгааг харуулж байна. Монгол Улсын хувьд 1990-ээд оноос эхлэн төрөлийн түвшин тогтвортойгоор буурсаар байгаа бөгөөд 1980-аад онд ТНК 6 буюу түүнээс дээш байсан бол 1990-ээд онд 3 буюу түүнээс доогуур түвшинд хүрч очсон байна. (ҮСГ, 1995)



**Эх үүсвэр:**

ҮСГ, 1994. Монгол Улсын хүн ам, Улаанбаатар

ҮСГ, 2001. 2000 оны Хүн ам Орон сууцны улсын тооллого: Үндсэн үр дүн, Улаанбаатар

1969 оны хүн амын нас, хүйсийн суваргаас харахад, 20-24 -өөс дээш насны бүлгүүдэд хүн амын тоо ерөнхийдөө ойролцоо бөгөөд цөөн насны бүлэгт хүн амын тоо ялгаатай байгаа ажиглагдаж байна. Энэ нь өнгөрсөн зууны эхний хагас дахь нас баралтын өндөр түвшин, улс төрийн тогтворгүй байдал, ялангуяа Дэлхийн хоёрдугаар дайны дараахь хэлмэгдүүлэлттэй холбоотой юм. 1969 оны хүн амын нас, хүйсийн суваргаас харахад суурь хэсгээрээ өргөссөн буюу төрөлтийн түвшин өсөж, нас баралтын түвшин буурч эхэлснийг харж болно. Тухайн үеийн Про наталист бодлого, сүм хийдэд олноор шавилан сууж байсан лам нарын тоо цөөрсөн, Европын анагаах технологийг нэвтрүүлсэн зэрэг нь 1940-1950-аад онд хүүхэд, залуу үеийнхний нас баралтыг бууруулж, суваргын суурийг өргөсөхөд (хүүхэд, залуу үеийнхний тоо нэмэгдэх) нөлөөлсөн юм. (Neupert, 1996). Хүн амын төрөлтийн түвшин үүний дараачийн 25 орчим жилд хэвээр үргэлжилсэн бөгөөд 2000 оны хүн амын нас, хүйсийн суваргаас хүн амын төрөлтийн түвшингийн бууралт 1990-ээд оноос эхэлсэн нь тодорхой харагдаж байна. 1969 оны суваргаас харвал 24-өөс дээш насны эмэгтэй хүн амын тоо эрэгтэй хүн амаас бага байв. Энэ нь эхийн эндэгдлийн өндөр түвшнээр тайлбарлагдах бөгөөд харин 1989 оны суваргад энэхүү байдал нь төдийлөн ажиглагдахгүй байна.

Хүснэгт 1-д хүн амын нас хүйсийн бүтцийг сонгосон үзүүлэлтүүдээр харуулав. Хүйсийн харьцаа нь 100 эмэгтэйд ногдох эрэгтэй хүн амын тоог харуулдаг. Монголын хувьд эрэгтэй, эмэгтэй хүн амын тоо бараг адилхан байна. Харин 2000 онд эмэгтэй хүн амын тоо ялимгүй өндөр болсон нь

магадгүй эмэгтэй хүн амын дундаж наслалтын өсөлттэй холбоотой байж болох талтай. Ерөнхийдөө ихэнх улс орны хувьд эмэгтэй хүн амын тоо арай илүү байх хандлага ажиглагддаг. Голч нас гэдэг нь хүн амыг тооных нь хувьд тэнцүү хоёр хэсэгт хувааж буй нас бөгөөд хүн амын тэн хагас нь голч наснаас залуу, тэн хагас нь голч наснаас дээш насны хүн ам байна гэсэн үг юм. (PRB, 2000). Монгол Улсын хувьд голч наснаас харахад ерөнхийдөө залуу хандлагатай ба 1969-1989 онд төдийлөн өөрчлөлт гараагүй байна. Харин 2000 онд мэдэгдэхүйц өссөн нь төрөлтийн бууралтын үр дүн гэж хэлж болно. Ерөнхийдөө голч нас нь 30 ба түүнээс дээш байвал хөгшин насны бүтэцтэй хүн ам гэж тооцогддог. Хүүхдийн ачаалал нь хөдөлмөрийн буюу 15-64 насны 100 хүн амд ногдох 0-14 настай хүүхдүүдийн тоогоор тодорхойлогдоно. Монголын хувьд хүүхдийн ачаалал бага байгаа нь залуу насны бүтэцтэй улс гэж дүгнэхэд хүргэж байгаа боловч төрөлтийн бууралтын улмаас 1990-ээд оноос энэхүү үзүүлэлт буурч байна. Харин хөгшчүүдийн ачаалал гэдэг нь хөдөлмөрийн насны 100 хүн ам тутамд ногдох 65 ба түүнээс дээш насны хүн амын тоогоор илэрхийлэгдэнэ. Монголын хувьд энэхүү үзүүлэлт нь хөгшин настай хүн амын хувийн жин бага байгааг харуулж байна. Нийт ачаалал нь хүүхэд ба хөгшин настай хүн амын ачааллын нийлбэр дүн юм.

*Хүснэгт 1. Нас, хүйсийн бүтцийг тодорхойлогч сонгосон үзүүлэлтүүд, Монгол Улс, 1969, 1979, 1989, 2000*

Үзүүлэлтүүд	Он			
	1969	1979	1989	2000
Хүйсийн харьцаа	99,4	99,8	99,5	98,5
Голч нас	18,7	17,3	18,6	21,6
Хүүхдийн ачаалал	89,6	88,8	78,3	58,9
Хөгшин насны хүн амын ачаалал	12,1	10,2	7,7	5,7
Нийт ачаалал	101,7	99,1	86,0	64,6
Хөгшрөлтийн индекс	13,5	11,5	9,9	9,7
“Асран халамжлагч”-ийн харьцаа	58,9	72,5	72,3	58,1

**Эх үүсвэр:**

ҮСГ, 1994. *Монгол Улсын хүн ам, Улаанбаатар*

ҮСГ, 2001. *2000 оны Хүн ам Орон сууцны улсын тооллого: Үндсэн үр дүн, Улаанбаатар*

Хөгшрөлтийн индекс гэдэг нь 0-14 насны 100 хүүхдэд ногдох 65-аас дээш насны нийт хүн амын тоогоор илэрхийлэгдэнэ. Эндээс Монгол Улсын нийт хүн амд хүүхдийн эзлэх хувийн жин өндөр, хөгшин насны хүн амын эзлэх хувийн жин бага байгааг харж болно. Хэрэв энэ үзүүлэлт 100-аас дээш байвал хөгшин насны бүтэцтэй хүн ам гэж үздэг. Хүн амын нас, хүйсийн бүтцийг тодорхойлогч бас нэг сонирхолтой үзүүлэлт бол “асран халамжлагчид”-ын харьцаа бөгөөд үүнийг 50-64 насны 100 эмэгтэйд ногдох 80-аас дээш насны хүн амын тоогоор тодорхойлно. Ихэнх улс орнуудад 80-аас дээш насны ахмадуудыг тэдний охид болох 50-64 насныхан асран халамжилдаг бөгөөд дээрх үзүүлэлт нь ахмадуудыг асран халамжлах хүний нөөц ямар байгааг харуулдаг ажээ. Монголын хувьд дундаж наслалтын доогуур түвшинтэй холбоотойгоор энэхүү

үзүүлэлт нэлээд бага байгаа буюу 2000 оны байдлаар 100 боломжит асран халамжлагчдад 14.4 настайчууд ногдож байна. Хөгшин насны бүтэцтэй улс орны хувьд энэ үзүүлэлт 50-аас илүү, зарим тохиолдолд 100-д ойрхон байдаг ажээ.

Насны бүтэцтэй холбоотой гарч ирдэг хамгийн чухал үзүүлэлт бол зорилтот насны бүлгүүд байдаг. Энэ нь тухайн улс орны нийгмийн зүгээс онцгой анхаарал шаарддаг насны бүлгүүд юм. Хүснэгт 2 ба Зураг 2-т 1969-2000 онууд дахь зорилтот насны бүлгийг харууллаа. Энэ нь боловсролын эрэлт хэрэгцээ ихтэй залуучууд болон хөдөлмөрийн зах зээлд их хэмжээгээр нийлүүлэгдэж байгаа, түүнчлэн орон сууцны асуудал хурцаар тавигдаж байгаа залуу насны болон насанд хүрсэн хүмүүс юм. Хөгшин насны хүн амын тоо бага байгаатай холбоотойгоор тэдний нийгэмд учруулах дарамт нь төдийлөн их биш байна. Дараагийн бүлэгтээ энэхүү нөхцөл байдал нь ирээдүйд хэрхэн өөрчлөгдөхийг харуулах болно.

Хүснэгт 2. Сонгосон зорилтот насны бүлгүүд, Монгол Улс, 1969, 1979, 1989, 2000

Зорилтот насны бүлгүүд	Нас (жилээр)	Хүн амын тоо				Хувийн жин (нийт хүн амд эзлэх)			
		1969	1979	1989	2000	1969	1979	1989	2000
Нялхас	0-1	38 323	59 015	71 539	49 804	3,2	3,7	3,5	2,1
Хүүхдүүд	1-4	160 478	208 946	259 582	196 219	13,4	13,1	12,7	8,3
Бага сургуулийн нас	8-11	130 538	173 856	212 571	249 699	10,9	10,9	10,4	10,5
Дунд сургуулийн нас	12-18	156 885	275 936	331 121	406 128	13,1	17,3	16,2	17,1
Хөдөлмөрийн нас	эрэгтэй: 15-59; эмэгтэй: 15-54	532 576	750 984	1 043 759	1 371	44,5	47,1	51,1	57,8
		231 136	338 141	480 329	561	646 535			
Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд	15-49	50 299	73 370	128 769	158 094	19,3	21,2	23,5	27,2
Өрх толгойлох насны эрэгтэйчүүд	22-28					4,2	4,6	6,3	6,7
Хөгшин насны хүн ам	65 ба түүнээс дээш	71 942	79 082	82 628	82 003	6,0	5,0	4,0	3,5
Нийт хүн ам		1 197 595	1 595 006	2 043 954	2 373 493				

**Эх үүсвэр:**

ҮСГ, 1994. Монгол Улсын хүн ам, Улаанбаатар

ҮСГ, 2001. 2000 оны Хүн ам Орон сууцны улсын тооллого: Үндсэн үр дүн, Улаанбаатар



**Эх үүсвэр:**

ҮСГ, 1994. Монгол Улсын хүн ам, Улаанбаатар

ҮСГ, 2001. 2000 оны Хүн ам Орон сууцны улсын тооллого: Үндсэн үр дүн, Улаанбаатар

**Монголын хүн амын бүтцийн ирээдүйн чиг хандлага**




Үндэсний Статистикийн Газар 2000 оны хүн ам, орон сууцны тооллогын мэдээлэлд үндэслэн хүн амын хэтийн тооцоог хийсэн. Энэхүү бүлэгт дээрх хэтийн тооцооны үр дүнг ашиглан хүн амын нас, хүйсийн бүтэц ирээдүйд хэрхэн өөрчлөгдөхийг авч үзэх болно. Хүснэгт 3-т 2000-2020 он хүртлэх хүн амын жилийн дундаж өсөлтийн түвшин ямар байхыг дунд хувилбараар тооцон гаргасныг харуулав. Хэтийн тооцоог төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний ирээдүйд өөрчлөгдөж болох чиг хандлага дээр үндэслэсэн болно. Хэтийн тооцоонд төрөлт буурна, (2000-2005 онд нэг эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин 2.4 байснаа 2015-2020 онд 1.9 болж буурна) нас баралт ч мөн адил буурна (2000-2005 онд дундаж наслалт эрэгтэй хүн амын хувьд 63.8 байснаа 2015-2020 онд 68.8, эмэгтэй хүн амын хувьд 68.8 байснаа 73.4 болно) гэсэн таамаглал дэвшүүлсэн бөгөөд хүн амын өсөлт маш удаан байх болно. Гэхдээ 1970-1980-аад оны хүн амын өсөлттэй холбоотойгоор удаан хугацаанд хүн ам нэгээс илүү хувиар өсөх учраас энэхүү өсөлтийг бага гэж үзэж болохгүй юм. Хүн амын төрөлт доогуур байх үеийн хүн амын өсөлтийг *хүн амын моментум* гэж нэрлэх бөгөөд энэ талаар дараагийн бүлэгт авч үзнэ.

Хүснэгт 3. Хүн амын хэтийн тооцоо, Монгол Улс

Онууд	Хүн амын тоо	Жилийн дундаж өсөлт (%)
2000*	2 389 661	
2005	2 562 261	1,40
2010	2 741 774	1,36
2015	2 918 624	1,26
2020	3 087 048	1,13


**Эх үүсвэр:** ҮСГ, 2002. 2000 оны Хүн ам Орон сууцны улсын тооллого: Монгол Улсын хүн амын хэтийн тооцоо, Улаанбаатар  
 ҮСГ, 2003. Монгол Улсын статистикийн эмхэтгэл., Улаанбаатар  
 \*2000 оны хүн амын тоо нь Хүснэгт 2-с ялгаатай байгаа болно. Хүснэгт 2 нь 2000 оны 1-р сарын 5-ны тооллогын дүн ба Хүснэгт 3-н мэдээлэл нь 2000 оны дундаж хүн амын тоо болно.

Зураг 3а-с 3в-д 2000, 2010, 2020 онд хүн амын нас, хүйсийн бүтэц ямар байхыг харуулжээ. Эдгээр суваргууд нь Зураг 1а-аас 1г-д харуулсан суваргуудын “хүлээгдэж буй” үргэлжлэл бөгөөд төрөлт, нас баралтын өндөр түвшнээс төрөлт, нас баралтын доогуур шатанд шилжиж буй хүн ам зүйн шилжилтийн үйл явцыг харуулж байна. Гэхдээ үүнийг хангалттай бууралт гэж үзэж болохгүй юм. Учир нь эмэгтэй хүн амын төрөлтөөс тооцсон дундаж наслалт нь 2000-2005 онд 68.8 жил байснаа 2015-2020 онд 73.4 жил болж нэмэгдэж байгаа боловч ихэнх хөгжингүй орнуудад дундаж наслалтын энэхүү хэмжээний уртсалт ойролцоогоор 10 жил байдаг байна.



**Эх үүсвэр:** ҮСГ, 2002. 2000 оны Хүн ам Орон сууцны улсын тооллого: Монгол Улсын хүн амын хэтийн тооцоо, Улаанбаатар

Дээрх суваргуудаас хүн амын насжилтын үйл явц, өөрөөр хэлбэл насанд хүрэгсэд болон хөгшин насны хүн амын өсөлт нь хүүхэд, залуучуудын өсөлтөөс илүү хурдан явагдахыг харж болно. Энэхүү чиг хандлага нь нэлээд аажим явагдах ажээ. Жишээлбэл, 2020 оны хүн амын суваргын суурь нь 1975-79, 1980-84 оны үелрэлтэй харьцуулахад (25-29 ба 30-34 настай) бага байгаа боловч бусад үелрэлүүдтэй харьцуулахад бага биш байна. Зураг 4-т 2020 оны хүн амын нас, хүйсийн суваргыг 2000 онтой харьцуулан үзүүллээ.



**Эх үүсвэр:**

ҮСГ, 2002. 2000 оны Хүн ам Орон сууцны улсын тооллого: Монгол Улсын хүн амын хэтийн тооцоо, Улаанбаатар

Өмнөх зургууд нь суваргын өөрчлөлтийг, ялангуяа 2000 оноос эхэлсэн өөрчлөлтийг харуулж байгаа ба суваргын хэлбэрийг ажиглавал хүн ам нь завсрын гэж хэлж болох хэв маягаас “төгс боловсорсон” хүн амд шилжиж буй шилжилт ажиглагдаж байна. Үндсэндээ 2020 оны хүн амын нас, хүйсийн суваргыг харвал залуу ба хөгшин хүн амын хоорондох завсрын шинжтэй байгаа боловч хүүхэд залуучуудын тоо харьцангуй өндөр байна. Залуу болон дунд насны хүн амын тооноос хүн амын төрөлт нь эргэн нөхөгдөх түвшинтэй ойролцоо байгааг харж болно.

Хүснэгт 4 ба 5, ялангуяа Хүснэгт 5 нь дараагийн 20 жилд Монголын хүн амын нас, хүйсийн бүтцийг харуулах үзүүлэлтүүд хэрхэн өөрчлөгдөхийг харуулав. Хүснэгтүүд хөдөлмөрийн насны хүн ам эрчимтэйгээр өсөж, харин хөгшин насны хүн ам удаанаар өсөхийг, цаашлаад залуу насны хүн амын буурахыг харж болно. Өмнө авч үзсэн төрөлтийн огцом гэж нэрлэгдээд байгаа бууралт нь бодит байдлаар нь авч үзвэл аажмаар буурч байгаа хэрэг юм. Учир нь өнгөрсөн үеийн төрөлтийн өндөр түвшин нь нөхөн үржихүйн насны хүн амын хувийн жин өндөр байхад хүргэж байгаа ба хэдийгээр төрөлтийн түвшин доогуур байгаа ч төрсөн хүүхдийн тоо их байна.



**Хүснэгт 4. Нас, хүйсийн бүтцийг тодорхойлогч сонгосон үзүүлэлтүүд, Монгол Улс, 2000, 2010, 2020**

Үзүүлэлтүүд	Он		
	2000	2010	2020
Хүйсийн харьцаа	98,5	98,5	98,3
Голч нас	21,6	25,4	30,2
Хүүхдийн ачаалал	58,9	40,1	35,1
Хөгшин насны хүн амын ачаалал	3,9	4,0	4,6
Нийт ачаалал	62,7	44,1	39,7
Хөгшрөлтийн индекс	6,6	10,0	13,2
“Асран халамжлагч”-ийн харьцаа	25,2	23,6	16,6

**Эх үүсвэр:**

ҮСГ, 2002. 2000 оны Хүн ам Орон сууцны улсын тооллого: Монгол Улсын хүн амын хэтийн тооцоо, Улаанбаатар

**Хүснэгт 5. Сонгосон зорилтот насны бүлгүүд, Монгол Улс, 2000, 2010, 2020**

Зорилтот насны бүлгүүд	Нас (жилээр)	Хүн амын тоо			Хувийн жин (нийт хүн амд эзлэх)		
		2000	2010	2020	2000	2010	2020
Нялхас	0-1	48 604	50 406	50 719	2,0	1,8	1,6
Хүүхдүүд	1-4	199 095	207 647	200 125	8,3	7,6	6,5
Бага сургуулийн нас	8-11	249 688	194 798	190 576	10,4	7,1	6,2
Дунд сургуулийн нас	12-18	406 128	371 918	360 395	17,0	13,6	11,7
Хөдөлмөрийн нас	эрэгтэй: 15-59; эмэгтэй: 15-54	1 323 005	1 690 055	1 824 786	55,4	61,6	59,1
Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд	15-49	650 939	820 050	871 700	27,2	29,9	28,2
Өрх толгойлох насны эрэгтэйчүүд	22-28	158 094	195 143	186 143	6,6	7,1	6,0
Хөгшин насны хүн ам	65 ба түүнээс дээш	82 561	109 196	147 227	3,5	4,0	4,8
Нийт хүн ам		2 389 661	2 741 774	3 087 048			

**Эх үүсвэр:**

ҮСГ, 2002. 2000 оны Хүн ам Орон сууцны улсын тооллого: Монгол Улсын хүн амын хэтийн тооцоо, Улаанбаатар



**Эх үүсвэр:**

ҮСГ, 2002. 2000 оны Хүн ам Орон сууцны улсын тооллого: Монгол Улсын хүн амын эхтийн тооцоо, Улаанбаатар

Энэхүү бүлгийг дараах асуултаар төгсгөх нь зүйд нийцэх болов уу. Монголын хүн амын нас, хүйсийн бүтцэд гарч буй өсөлт, өөрчлөлт нь нийгэм эдийн засгийн хөгжлийн үйл явцад ямар эерэг нөлөөтэй байна, эсрэгээр хүн амын сайн сайхан байдал болон эдийн засгийн хөгжилд ямар нэгэн саад учруулж байна уу? Энэхүү асуултанд хариулахын тулд хүн ам зүйн ном зохиолд олонтаа дурьдагддаг боловч цөөн судлагдсан *хүн амын моментум* гэсэн үйл явцыг гүнзгийрүүлэн судлах нь зүйтэй юм.

**Хүн амын моментум**

Хүн амын моментум гэдэг нь хүн ам өөрөө эргэн нөхөх түвшинд хүрсний дараах үеийн хүн амын үргэлжлэн өсөх хандлагыг хэлнэ. Өнгөрсөн үеийн өндөр төрөлт нь залуу насны хүн амын өндөр хувийн жин эзлэхэд хүргэдэг. Эдгээр залуу насны хүн ам, хүүхэд төрүүлэх насанд байх хугацаанд төрөлтийн түвшин нас баралтыг давсаар байна. Энэ насны томоохон бүлэг хүн ам хөгширч нас барснаар хүн амын моментум зогсоно. Нас баралт төрөлттэй тэнцэж эсвэл төрөлтөөс давж хүн амын өсөлт зогсонги байдалд ордог. Төрөлтийн эргэн нөхөгдөх түвшин гэдэг нь хосууд өөрсдийгөө нөхөх, хоёр эсвэл хоёроос үл ялиг илүү тооны хүүхэдтэй байх төрөлтийн түвшинг хэлнэ. Гэхдээ энэ нь яг хоёр хүүхэдтэй байна гэсэн үг бус, нас баралтыг бас тооцож тусгасан байдаг (PRB, 1998; Rowland, 2003).

Энэхүү хэсэгт Монголын хүн амын моментумыг судлах болно. Юуны өмнө Зураг 1-ийг харна уу. Зургаас харахад нөхөн үржихүйн, ялангуяа 15-39 насны эмэгтэй хүн амын тоо түүнээс дээш насны бүлгийн эмэгтэйчүүдтэй харьцуулахад их байна. Мөн 1970-1980 аад оны ТНК 6 ба түүнээс дээш түвшинд хүрч байсан өндөр төрөлт болон нас баралтын тогтвортой бууралтын үр дүнд 10-14 насны хүн амын тоо их байна. Өмнө өгүүлсэнчлэн, суваргын суурь хэсгийн эхний 2 үелрэл нь төрөлтийн бууралттай холбоотой юм. Гэхдээ эдгээр үелрэлүүд нь төрөлтийн бууралтын хэмжээ төдийлөн их биш байгааг харуулж байна. Тухайлбал: ТНК 1990 онд 6.4 байснаа 1995 онд 2.8, 2000 онд 2.2 болж буурсан байна. (ҮСГ, 2003). Хүснэгт 3в-д 2020 оны хүн амын нас, хүйсийн бүтэц

ямар байхыг тооцоолон харуулжээ. Суваргаас харахад төрөлт тогтвортой буурч байгаа хандлага ажиглагдаж байгаа (25-29 нас) ба хэтийн тооцоонд (нэг эмэгтэйд ногдох хүүхдийн тоо 2-с ялимгүй өндөр) таамаглагдаж байгаа шиг доогуур төрөлт биш байна. Өмнө өгүүлсэнчлэн, төрөлтийн түвшин доогуур байсан ч хүн ам одоогийн болон дараагийн 10 жилд өссөөр байх болно. Хүн амын өсөлтийн түвшин нь жилд 1 ба түүнээс дээш хувь байх бөгөөд энэхүү хандлагыг *хүн амын моментумаар* тайлбарлана.

Хүн амын моментумыг судлах өөр нэг хандлага бол үелрэл бүрэлдэхүүний аргаар *стационарь хүн амын* хэтийн тооцоонд үндэслэн судлах арга юм. Стационарь хүн ам гэдэг нь төрөлтийн эргэн нөхөгдөх түвшин болон нас баралт нь тогтонги хүн ам юм. Үүний үр дүнд хүн амын өсөлт нь тэг байх ба ойролцоогоор 100 жил насны бүтэц хэвээр хадгалагддаг байна. Түүнчлэн тухайн улсын хүн ам 100 жилд төрөлтийн эргэн нөхөгдөх түвшин тогтмол, нас баралт буюу дундаж наслалт тогтмол, шилжих хөдөлгөөн байхгүй гэж таамагласан үед бүхэл бүтэн зууны дараа хүн ам стационарь болох ажээ. (Rowland, 2003). Моментумын түвшинг эхний хүн амын хэмжээтэй харьцуулан тодорхойлох ба энэхүү өсөлтийг хувиар илэрхийлнэ.

Хүснэгт 6-ийн эхний баганад 2000 оны дунд үеийн тооллогын хүн амыг нас баралт нь тогтмол: дундаж наслалт эмэгтэй хүн амын хувьд 68.1, эрэгтэй хүн амын хувьд 63.8 байхаар таамаглал дэвшүүлжээ. ҮСГ-с 2000-2004 оны хүн амын хэтийн тооцоог хийхдээ нас баралтын түвшин нь ийм байхаар таамаглал дэвшүүлсэн байна. (ҮСГ, 2002). Төрөлтийн эргэн нөхөгдөх түвшин буюу нэг эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин нь 2.24 гэж таамаглагдсан. Ийнхүү таамаглал дэвшүүлсний дараагаар хэтийн тооцоо хийхэд 100 жилийн дараа хүн ам 3,769,627 болох ажээ. Үүнээс харахад 2000-2100 он хүртлэх 100 жилийн хугацаанд хүн ам 1.38 саяар буюу 57.7 хувиар өсөх юм. Энэ нь моментумын хэмжээг харуулж байна. Ерөнхийдөө, Монгол Улсын хүн амын төрөлт ба нас баралтын чиг хандлага 2000-2004 оныхтой адил байвал 100 жилийн дараа хүн ам 57.7 хувиар өснө гэсэн үг юм. Цаашилбал, төрөлт буурсан ч хүн ам 2060 он хүртэл өснө гэдгийг харуулж байна. Үүний дараагаар хүн ам зүйн зарим үзүүлэлтүүд тогтвортой байвал хүн амын өсөлт зогсох ба зарим үзүүлэлтүүд тогтворжих хандлагатай болно. Энэ нь хэрэв төрөлт одоогийн түвшинтэйгээ ойролцоо буюу одоогийн түвшнээ хадгалж чадвал хүн амын өсөлтөнд нэг их бууралт ажиглагдахгүй, өөрөөр хэлбэл хүн ам абсолют хэмжээгээрээ буурах болоогүй гэдгийг харуулж байна. Хэрэв нас баралт буурвал хүн амын моментум нь 2060 оноос цааш хүн амыг өсөхөд хүргэж болох юм.

Хүснэгт 6. Төрөлт, нас баралтын ялгаатай түвшинд үндэслэсэн хэтийн тооцоо, Монгол Улс

	Ялгаатай төсөөллүүд дэх хэтийн тооцоо			
	ТНК=2.24	ТНК =1.80	ТНК =2.50	ТНК =2.24
	$e(0)_{эp}=63.8$	$e(0)_{эp}=63.8$	$e(0)_{эp}=63.8$	$e(0)_{эp}=73.3$
Он	$e(0)_{эм}=68.1$	$e(0)_{эм}=68.1$	$e(0)_{эм}=68.1$	$e(0)_{эм}=78.0$
2000	2 389 661	2 389 661	2 389 661	2 389 661
2010	2 746 436	2 649 330	2 803 642	2 825 826
2020	3 136 387	2 928 155	3 259 144	3 309 833
2030	3 422 935	3 090 119	3 625 108	3 707 207
2040	3 606 277	3 105 974	3 922 593	4 020 622
2050	3 725 150	3 035 615	4 175 251	4 270 352
2060	3 758 922	2 871 846	4 359 273	4 426 269
2070	3 752 880	2 655 586	4 525 889	4 528 888
2080	3 766 454	2 466 725	4 720 765	4 646 275
2090	3 773 774	2 298 010	4 909 437	4 761 349
2100	3 769 627	2 124 851	5 099 169	4 861 861


**Эх үүсвэр:** 2000 оны Хүн ам Орон сууцны улсын тооллого: Монгол Улсын хүн амын хэтийн тооцоо-нд үндэслэн судлаачдын хийсэн хэтийн тооцоо

Хүснэгт 6-ийн хоёр дахь баганад төрөлтийн түвшин доогуур буюу ТНК 1.8 байх үед хүн ам хэрхэн өөрчлөгдөхийг тооцож үзье. Харин төрөлтөөс тооцсон дундаж наслалтыг өмнөх тооцоололтой адил байхаар таамаглал дэвшүүллээ. Энэ үед хүн ам моментумаараа 2040 он хүртэл өсөх бөгөөд энэ хугацаанд хүн ам 716,313-р нэмэгдэх ба өсөлтийн хувь 30 байх ажээ. 2040 оны дараагаас хүн амын бууралт ажиглагдаж эхэлнэ. Гэхдээ энэ нь хүн амын төрөлтийн түвшин доогуур байсан ч хүн ам 40 жилийн туршид өснө гэдгийг харуулж байна. Хүснэгт 6-н 3-р баганад ТНК-г 2.5 байхаар таамаглав. Харин дундаж наслалтыг өмнөх 2 тооцоололтой адилхан байхаар төсөөллөө. Энэ тохиолдолд хүн ам энэ зууны төгсгөл гэхэд 5 саяд хүрэх ажээ. Хүснэгт 6-н 4-р баганад ТНК нь одоогийнхтой адилхан түвшинд буюу нэг эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин 2.24, харин төрөлтөөс тооцсон дундаж наслалт эрэгтэйчүүдийн хувьд 73.3, эмэгтэйчүүдийн хувьд 78.0 байна гэж төсөөлсөн. Дундаж наслалтыг ийнхүү авсан нь санамсаргүй зүйл биш бөгөөд, ҮСГ-аас хийсэн 2025 оны Улаанбаатар хотын хүн амын дундаж наслалтын хэтийн тооцооллыг ашигласан. Өөрөөр хэлбэл, эрүүл мэнд, боловсрол, сайн сайхан байдалд хангалттай хөрөнгө оруулалт хийхийн тулд хүн амыг хэд хүргэх вэ гэсэн асуултын хариу юм. Энэхүү таамаглалын үндсэн дээр хүн амын ирээдүйн хэмжээг тодорхойлбол 2100 онд 4.9 сая болох ажээ.

Хүснэгт 6-ийн 3 ба 4-р баганын хувьд нэг нь зөвхөн төрөлт өссөн үед, нөгөө нь зөвхөн нас баралт буурсан үед хүн ам хэд болохыг харьцуулахад ихээхэн ач холбогдолтой. Таамаглагдаж буй төрөлтийн өсөлт нь төдийлөн өндөр биш юм. Ихэнх улс орнуудын жишгээс харахад хэрэв төрөлт буурвал түүнийг эргэж нэмэгдүүлэхэд нэлээд төвөгтэй

байдаг. (Weeks, 2002). Өндөр хөгжилтэй боловч төрөлтийн түвшин нь доогуур байгаа улс орнуудад төрөлтийг аль болох нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлдэг байна. Эдгээрийг 3 хэсэгт ангилан үзэж болно. Үүнд: Санхүүгийн дэмжлэг/туслалцаа үзүүлэх, албан байгууллага, нийгэмд эцэг эхийг нь дасган төлөвшүүлэх, хүүхэд болон эцэг эхэд нийгмийн талаас нь тусламж үзүүлэх зэрэг багтана. (McDonald, 2002). Дээрх арга хэмжээнүүд нь харьцангуй зардал ихтэй. Жишээлбэл, санхүүгийн тусламж нь гэр бүлд төдийгүй хүүхдүүдэд олгогддог. Хүүхэд асарсны тэтгэмж нэлээд өндөр өртөгтэй. Мөн эцэг, эхчүүдийн хүүхдээ асарч байх хугацаанд төлөгдөх нийгмийн хамгааллын төлбөр нэлээд өндөр өртөгтэй. Монголтой адил улс орны хувьд дээрх про наталист арга хэмжээнүүдэд зарцуулах нөөцийг нийгмийн үйлчилгээг сайжруулж, өргөжүүлэх, дэд бүтцэд хөрөнгө оруулах чиглэлээр ашиглаж болох юм. Энэхүү төсөөлөл нас баралт буурна гэж таамаглагдсан. Хүн амын төрөлт эргэн нөхөгдөх түвшиндээ байвал 2100 он гэхэд хүн ам 5 саяд хүрнэ. Хоёр таамаглалыг харьцуулбал, 2070 он хүртэл нас баралт буурсан гэж таамаглаж буй (4 дэх төсөөлөл) төсөөллөөр тооцоологдсон хүн ам нь төрөлт өсөж, нас баралт тогтвортой байна гэсэн таамаглалын үндсэн дээр тооцоологдсон хүн амаас (3 дахь төсөөлөл) илүү өссөн байна. Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, нийгмийн эмзэг бүлгийнхний амьжиргааны түвшинг дээшлүүлэх зэрэг нь юуны өмнө нас баралтыг бууруулах ба энэ нь про наталист бодлогоос бага зардалтай байх болно. Улмаар энэ нь хүн амын өсөлтийг хангах бөгөөд илүү мэдрэмжтэй, зөв, оновчтой бодлоготой байхыг харуулж байна.

Зураг 6-д таамаглагдаж буй 4 төсөөлөл дэх хүн амын өөрчлөлтийг дүрслэн харуулав. Гурав ба 4 дэх төсөөллийн дагуу тооцоолсон хүн ам ерөнхийдөө ойролцоо байна. Өмнө үзсэнээр, зөвхөн 2070 онд төрөлтийн эргэн нөхөгдөх түвшин нь өндөр байхаар төсөөлөн тооцоолсон хүн ам нь нас баралтын түвшин доогуур байна гэж төсөөлөн тооцоолсон хүн амаас ялимгүй илүү гарахыг харж болно.



**Эх үүсвэр:** 2000 оны Хүн ам Орон сууцны улсын тооллого: Монгол Улсын хүн амын хэтийн тооцоо-нд үндэслэн судлаачдын хийсэн хэтийн тооцоо

Энэ нь стационарь хүн амын загварыг ашиглан бодит байдлыг тодорхойлж буй судалгаа юм. Бодит хүн ам нь загвараар тодорхойлогдсонтой адил байх нь цөөн бөгөөд, түүнээс хэр зэрэг ялгаатай байх эсэх нь нэлээд сонирхолтой байдаг. Энэхүү шинжилгээний

үр дүн нь төрөлт одоогийн доогуур түвшиндээ хадгалагдаж, эсвэл одоогийнхоосоо илүүтэй буурсан ч Монгол Улсын хүн ам өсөх болно гэдгийг харуулж байна. Түүнчлэн, төрөлтийг өсгөхөөс илүү нас баралтыг тогтвортой бууруулах нь хүн амыг өсөлтийг хангахад чухал нөлөөтэй байна.

## **Хэлэлцүүлэг**

Хүн амын өсөлтийн тухайн түвшингээ хэвээр хадгалах эсвэл дэмжих бодлого баримталдаг улс орнуудыг хоёр бүлэгт хувааж болох юм. Эхний бүлэгт төрөлт бага, хүн амын өсөлт удаан, өндөр хөгжилтэй Европ, Хойд Америкийн орнууд, түүнчлэн Япон зэрэг улсууд багтана. Засгийн газрууд нь хүн амынхаа өсөлтийг эдийн засгийн дутагдаж буй хүчин зүйл гэдгийг хүлээн зөвшөөрч, ажиллах хүчний хомсдол, одоо болон ирээдүйд улам өсөх хандлагатай байгаа тэтгэврийнхэн буюу өндөр настны тоо нэмэгдэж байгааг олж хараад байна. Хоёр дахь бүлэг нь хуучинсаг, гэр бүлийн талаархи уламжлалт ойлголт ноёрхдог, мөн үндэсний зорилтоо биелүүлэхэд хүн амын удаан өсөлт нь сөрөг нөлөөтэй гэсэн байр сууринаас хүн амынхаа өсөлтийг бага гэж үздэг, хөгжиж буй орнуудын төлөөлөл юм (Weeks, 2002). Хөгжиж буй зарим улсуудад төрөлтийг дэмжих пронаталист бодлогыг хуульчилсан байдаг ч бодлогын хэрэгжилтэнд хүн ам зүй, нийгэм, эдийн засаг, экологийн талаас нь судлан шинжилж, бодит үндэслэлтэй хандах нь чухал юм. Манай орны хувьд, гурван гол асуудлын хүрээнд анхаарлаа хандуулах хэрэгтэй байна.

Юуны өмнө хөгжиж буй орнуудын хувьд нэн тэргүүнд хүн амын өсөлт ба эдийн засгийн хөгжлийн хоорондын харилцан хамаарал байгааг авч үзэх нь чухал. Энэхүү харилцан хамаарлыг гурван асуултаар хураангуйлан нэгтгэж болох юм (Weeks, 2002). Үүнд:

Хүн амын өсөлт эдийн засгийн хөгжлийг хурдасгах уу?

Хүн амын өсөлт нь эдийн засгийн хөгжилтэй хамааралгүй юу?

Хүн амын өсөлт нь эдийн засгийн хөгжилд хохирол үзүүлэх юу?

Хүн амын өсөлт ба эдийн засгийн хөгжил гэсэн хоёр хувьсагчийн хоорондын хамаарлын талаар хийгдсэн олон судалгаануудад энэхүү хамаарал эерэг, зарим нь сөрөг, нэг хэсэг нь бүр харилцан хамааралгүй болох тухай дүгнэсэн байдаг (Cassen, 1994). Нэлээд сүүлийн үеийн судалгаанууд уг асуудлыг дан ганц макро эдийн засаг талаас нь бус микро түвшинд илүү маргаантай байгаа асуудал болгон авч үзэж байна. Тухайлбал, хүн амын өсөлтийн ядууралд үзүүлэх үр нөлөө, эмэгтэйчүүдийн үүрэг, эрүүл мэнд, хүний нөөцийн хөгжил, байгаль орчин, шилжих хөдөлгөөн зэрэг асуудлуудыг хөндөж судалсан байдаг. Ихэнхи судалгааны үр дүн төрөлтийн түвшин өндөр хөгжиж буй орнуудын хөгжлийн олон зорилтуудад хүн амын хурдан өсөлт нь сөрөг нөлөөтэй болохыг харуулсан байдаг. Энэ нь төрөлт болон хүн амын өсөлтийн бүх түвшинд, бүхий л цаг хугацааны туршид улс орнуудын баялаг, тэдгээрийн хүн амын хэмжээг үл тоомсорлосон болон хөгжлийн бүхий л аспектиудад хамаагүй гэсэн үг биш юм. Гэхдээ ерөнхийд нь авч үзвэл олонхи судалгаанууд хөгжлийн олон зорилтууд нь бага төрөлтийн түвшин, хүн амын удаан өсөлтийн үед илүү амжилттай хэрэгжинэ гэж дүгнэсэн байдаг (Cassen, 1994).

Хүүхэд болон өсвөр үеийнхний хувийн жин өөрчлөгдөж, өсөлт хурдацтай буурах тохиолдолд манай орны хөгжил болон гэр бүлийн сайн

сайханд ашигтай байж магадгүй юм. Хүн амын ачаалал эрүүл мэнд, боловсролын системд бага туссанаар хүн амд хүргэх үйлчилгээ сайжрахаас гадна газар зүйн болон нийгмийн бүлгүүдийг илүү өргөн цар хүрээтэй хамрах боломжтой болно. Өрхийн түвшинд, гэр бүлүүд олон хүүхдэд санхүүжилт хийхийн оронд өөрсдийн сайн сайхан амьдралын төлөө хөрөнгө оруулах боломжтой болно.

Энэ 10 жил болон ирэх 10 жилд манай улсын хүн амын насны бүтэц эдийн засгийн үйл явцад нэн таатай нөлөөтэй байх болно гэсэн байр сууринаас асуудалд хандах нь чухал юм. Нийт хүн амын дотор хүүхэд насны хүн амын эзлэх хувийн жин багасч, өндөр настны эзлэх хувийн жин төдийлэн нэмэгдэхээргүй байна. Үүнтэй уялдан нийгмийн бусад зардлуудад зориулагдаж буй нөөцийг улс орныхоо дэд бүтцийг сайжруулахад шууд зарцуулах боломж бүрдэж байгаа юм. Түүнчлэн хөдөлмөрийн насны хүн амын тоо нэмэгдэх болно. Эдийн засгийн хөгжлийн хурдац нэмэгдэхийн хэрээр ажиллах хүчний нөөцийг үр дүнтэй эргэлтэд оруулж эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг бий болгоно. Хүн ам зүйн ийм үе шатыг эерэг утга агуулгаар нь *“хүн ам зүйн урамшуулал”* гэж нэрлэдэг.

Манай улсын өнөөгийн болон ирээдүйн хүн амын насны бүтэц нь Азийн олон улс, орнуудын нэгэн адил эдийн засгийн хөгжлийн үйл явц эрүүлжих нөхцөл *“хүн ам зүйн урамшуулал”* болж болохоор байна. Гэхдээ манай улсын эдийн засгийн уламжлалт үндэс суурь нь нүүдлийн мал аж ахуй гэдгийг анзаарч үзвэл, энэ салбарт ядуу малчдыг бий болгохгүйгээр хөдөлмөр эрхлэх насны хүн амыг шингээх эсэх, байгаль орчны сөрөг үр дагаврууд, албан бус секторын хамгийн доогуур зэрэглэлд амь зууж буй хот руу шилжин ирэгчдийн түлхэж буй хүчин зүйлсийг арилгах зэрэг асуултууд гарч болох юм. Мал аж ахуйн эсвэл эдийн засгийн бусад салбарт ирээдүйн ажиллах хүчнийг шингээх үр дүнтэй ажил эрхлэлтийг бий болгох хангалттай хөрөнгө оруулалт орж ирэх үү? Уг асуултанд бидний хийсэн судалгааны ажил хариулт өгөх боломжгүй хэдий ч эдгээр нөхцөл байдалд нухацтай судалгаа, шинжилгээний ажил хийх шаардлагатай байна.

*Хоёр дахь* чухал сэдэв нь *хүн амын моментум* юм. Өмнөх хэсэгт өгүүлсэнчлэн төрөлтийн түвшин бага боловч хүн амын өсөлт үргэлжлэх болно. Үүнтэй уялдан тодорхой түвшинд хүртэл Монголын хүн амын өсөлтийг нэмэгдүүлэх нь зайлшгүй юу эсвэл үгүй юу гэсэн асуулт гарч байна. Хэрвээ төрөлт эргэн нөхөгдөх түвшиндээ хэвээр байвал дараагийн 50 жилийн туршид хүн ам үргэлжлэн өссөөр байх талаар өмнөх хэсэгт харуулсан билээ. Энэхүү өсөлт нь нас баралтын эрчимтэй болон тогтвортой бууралтын үйл явцтай зэрэгцэх болно. Иймд манай орны хувьд хүн амын өсөлтийн асуудал улс орны төлөвлөсөн ашиг сонирхлоос илүү байх уу? Өөрөөр хэлбэл, хүн амын өсөлтийг нэмэгдүүлэх төрөлтийн пронаталист бодлого нь манай орны хувьд чухал гэж үзэж болох уу? гэсэн дараагийн логик асуулт гарч ирнэ. Бүлгийн эхэнд авч үзсэн нэг дэх асуудлын адилаар энэ удаа бүрэн төгс хариулт өгөх боломжгүй юм. Гэхдээ энэ сэдвийг судлах, хэлэлцүүлэх нь чухал байна.

Хүн амын хурдацтай өсөлт хөгжилд тустай гэж үзэх зарим нэг үндэслэл байдаг. Европ болон АНУ-ын хөгжлийн түлхүүр нь хүн амын түргэн болон зохистой өсөлт байв. Зарим түүхчдийн үзсэнээр Европ дахь аж үйлдвэрийн хувьсгалын томоохон хүчин зүйл нь нас баралтын бууралт, түүнээс үүдэлтэй хүн амын өсөлт байсан юм. Түүхэн талаас нь

өнөөгийн аж үйлдвэржсэн орнуудын хөгжилд хүн амын өсөлтийн эерэг нөлөөг олж харж болох боловч тэдгээр орнууд болон өнөөгийн хөгжиж буй улс, орнуудын хооронд асар их ялгаа байгаа билээ. Өнөөдөр хөгжил буурай орнууд хөгжингүй орнуудын хөгжлийн үе шатыг нь давтахгүй байна. Тухайлбал, хөгжилтэй орнуудын хөгжлийн алхмаа эхэлж байсан үетэй харьцуулахад ажлын байр бий болгох хөрөнгө, санхүүжилтын хэмжээ өнөөдөр хэд дахин их байна. Хөгжингүй орнуудын түүхийн харьцуулж болох үе шатанд байгаа өнөөгийн буурай хөгжилтэй орнууд эдийн засгийн өсөлтийн хувьд тухайн үеийнхээс хавьгүй илүү байгаа ба харин хүн амын өсөлт нь харьцангуй өндөр байна. Өөрөөр хэлбэл, хөрөнгө шингээлт ихтэй технологи, хүн амын хурдан өсөлт нь ажлын байрыг бий болгох шалгарсан арга зам биш бөгөөд тогтвортой хөгжлийн үйл явцыг хангахгүй болох нь харагдаж байна. Нийгэм, эдийн засгийн хөгжлийг хүн амын өсөлтөөр дэмжиж байхын тулд хүн амын өсөлт тодорхой бүтэц, зааг хязгаарт багтаж, тэрхүү бүтцийн болон удирдлага зохион байгуулалтын орчноос хамаарч хүн амын өсөлтийн эерэг, сөрөг нөлөө илрэх болно. Иймд агуулгын энэ тал болон хүн амын өсөлтийн хооронд харилцан хамаарлыг цогц байдлаар системтэйгээр судлах нь хамгаас чухал юм.

Эдийн засгийн хөгжлийн эхлэл нь хөрөнгө оруулалт гэдэгт анхаарах нь чухал юм. Хөрөнгө нь зөвхөн тоног төхөөрөмж, барилга байшинд бус, харин хүний капиталд тухайлбал, боловсрол, эрүүл мэнд, мэдлэг олж авах, хэрэгжүүлэхэд зарцуулагдах хэрэгтэй. Эдийн засгаа өсгөхийн тулд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ёстой. Хүн амын өсөлтийн өндөр түвшинд хөрөнгө оруулалтын өндөр түвшин байх ёстой. Хэрвээ тухайн улс орны хүн амын өсөлт нь хөрөнгө оруулалтын түвшингээс давж байвал тэр улс орон ядуурлын тойргоос гарч чадахгүй. Эдийн засгийн өсөлт нь олон хүнийг тэжээж чадах хэдий ч ядуурлаас бүгдийг нь хамгаалахад хүрэлцэхгүй (Weeks, 2002; Leibenstein., 1957). Иймд өнөөгийн хөгжил буурай орнуудад олон хүн ам бус харин хүний нөөцийн чанар илүү чухал бөгөөд аливаа зорилгоо цөөн хүн ам дээр л хэрэгжүүлж чадна.

Гурав дахь сэдэв бол хөгжиж байгаа орны төрөлтийг дэмжих бодлогын бодит үр нөлөөг авч үзэх болно. Дээр дурьдсанчлан төрөлтийг нэмэгдүүлэх бодлого нь өртөг ихтэй байхаас гадна үр дүн нь тун эргэлзээтэй байдаг. Энд таван жишээг эргэцүүлэн авч үзье.

Сингапурын Засгийн газар 1965 онд тусгаар тогтнолынхоо дараа эхлээд гэр бүл төлөвлөлтийн арга дээр суурилсан төрөлтийг бууруулах хүчтэй бодлогыг, дараа нь хоёр ба түүнээс олон хүүхэдтэй хосуудын тоог аажмаар бууруулах бодлогыг баримталжээ. Сингапурын төрөлтийн нийлбэр коэффициент (ТНК) буюу нэг эмэгтэйн төрүүлсэн дундаж хүүхдийн тоо 1966-1985 оны хооронд 4.5-1.5 хүүхэд хүртлээ буурсан юм. Эдийн засаг, нийгэм, улс төрийн олон янзын нөхцөл байдлын улмаас Засгийн газар нь төрөлтийг дэмжих эрчимтэй арга хэмжээнүүдийг авахаар бодлогоо өөрчилсөн байна. Гол санаа нь ажил эрхэлж байгаа эхчүүдэд хүчтэй дэмжлэг үзүүлэхүйц гэр бүлийг дэмжих бодлого байв. Засгийн газраас ажил эрхэлж буй эхэд нийтлэг татварын хөнгөлөлт үзүүлэх, ажил олгогчдын зүгээс хүүхэд нь өвдсөн үед асарч байгаа эхчүүдэд тусгай чөлөө олгох, мөн төсвөөс хүүхдийн асаргааны мөнгийг аль болох нэмэгдүүлэхэд анхаарч байв (Тармужи, 1999). Энэ бүх арга хэмжээний зорилго нь төрөлтийг эргэн нөхөгдөх түвшинд хүртэл нь нэмэгдүүлэх явдал байжээ. Гэвч энэ зорилго биелэгдээгүй бөгөөд 1990-



ээд оны сүүл гэхэд ТНК 1.8 болж өсчээ. Энэхүү өсөлт нь залуу насны эмэгтэйчүүд төрөлтөө хойшлуулсантай холбоотой байж болох юм. 2000 оны байдлаар нэг эмэгтэйд ногдох хүүхдийн тоо буюу ТНК=1.5 болтлоо эргээд буурсан байна (Weeks, 2002).

Хуучнаар Бүгд Найрамдах Ардчилсан Герман улсад 1976 онд төрөлтийг урамшуулах нэлээд хэдэн арга хэмжээ авагджээ. Тухайлбал, хүүхэд төрүүлсэн эхчүүдэд цалингийнх нь 70-80 хувьтай тэнцэх тэтгэмж, нийгмийн бусад тэтгэлэг олгохын зэрэгцээ төрсний дараа нэг жилийн хугацаатай амралт эдлүүлж байв. Гэсэн хэдий ч зарим эмэгтэйчүүдийн гэрлэлт нэмэгдсэн атал төрөлт нэмэгдээгүй юм (van de Kaa, 1987; Monnier, 1990).

Франц нь дэлхийн бусад улс орнуудтай харьцуулахад урт хугацааны туршид төрөлтийн бага түвшинтэй байсан юм. Францын Засгийн газраас 2 ба түүнээс дээш хүүхэдтэй хосуудад сар бүрийн тэтгэлэг олгож байсан ч уг тэтгэлэг төрөлтөд нөлөөлж буй эсэхийг бодитой илэрхийлэх боломжгүй байна. Ганц бие эхчүүд мөн нэгэн адил сар бүрийн тэтгэлэг улсаас авдаг ба Францын бүх эхчүүд хүүхдээ 3 нас хүртэл нь хүүхэд асрах газраар үйлчлүүлж, хүүхдээ өсгөхийн зэрэгцээ ажлаа ая тухтай хийх нөхцлөөр хангагдсан байдаг байна (Bergman, 1996). Ийм аргаар төрөлтийг нэмэгдүүлэх үр нөлөө хангалттай биш боловч ТНК 1.8 болоход хувь нэмэр үзүүлсээр байгаа ба Европ дотроо хамгийн өндөр төрөлттэй орны нэг болоод байна.

Урьдчилан тооцоогүй хүчин зүйлүүдийн улмаас төрөлтийг дэмжих бодлого амжилтанд хүрэхгүй байх тохиолдол байдаг. Жишээ нь Чилид 1970-80 оны үед Пиночетийн засгийн газар үндсэрхэг үзэл санааны үүднээс хүн амаа өсгөх тухай уриалсан байна. Харамсалтай нь үйл явдал эсрэгээр эргэжээ. 1973 оны цэргийн эргэлтээр Аллендегийн Засгийн газар унасны дараа Пиночетийн засаг захиргаа татварын журмыг чангатгаснаар орлого зогсож, ажилгүйдлийн түвшин нэмэгдсэн байна. Үүнтэй уялдан гадагш шилжих хөдөлгөөн, орой гэрлэлт нэмэгдэж, гэрлэгчид жирэмслэлтээс сэргийлэх арга, хэрэгслийг өргөн хэрэглэх болжээ. Хүн ам өсөөгүй нь ойлгомжтой бөгөөд харин бууралтын үйл явц үргэлжилсэн байна.

Төрөлтөө бууруулах хүн амын шийдвэр дэх нөхөн үржихүйн зан үйлийг өөрчлөх нь нэлээд хүндрэлтэй байдаг. 1996 онд Румыны Засгийн газар хүн амын төрөлт бууралтын хандлагыг зогсоохын тулд үр хөндөлтийг хориглосон бодлого гаргасан боловч хууль бус үр хөндөлт хийгдсээр байв. Түүнчлэн Засгийн газар гаднаас импортоор орж ирсэн жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл хэрэглэхийг хориглосон байна. Богино хугацаанд төрөлтийн түвшин өссөн боловч 1987 онд нууцаар үр хөндүүлэх явдал нэмэгдэж эхэлсэн төдийгүй гэр бүл төлөвлөлтийн бусад аргуудын /ихэвчлэн хуанли хөтлөх, угаалга хийх/ хэрэглээ нэмэгджээ. 1966 онд ТНК 1.9 байснаа 1989 онд 2.3 болж болж бага зэрэг нэмэгдсэн байна. Румыныг удаан хугацаагаар удирдсан Николай Чеуйжескугийн засаглал 1989 онд төгсгөл болж, эрх мэдлийг өөрчилсөн юм. Шинэ Засгийн газрын анхны хууль эрх зүйн баримт бичиг нь эхийн эндэгдлийг бууруулах зорилгоор үр хөндөлтийг хуулиар зөвшөөрсөн явдал байв (Serbanescu, et al. 1995). 2000-аад оны эхэн гэхэд ТНК 1.3 болж буурчээ.

Эдгээр жишээнүүд нь нэгэнт буурчихсан төрөлтийн түвшин, ялангуяа нөхөн үржихүйн эргэн нөхөгдөх түвшинд ойр байгаа төрөлтийн түвшинг нэмэгдүүлэхэд хэр төвөгтэй болохыг илтгэн харуулж байна. Төрөлтийг дэмжих Засгийн газрын бодлогууд нь өртөг зардал их, бага

байхаас үл хамааран төрөлтийн түвшинг үл мэдэг нэмэгдүүлдэг эсвэл огт нөлөөгүй байдаг байна.

Аль ч тохиолдолд, улс орон хүн амаа өсгөх нь зөв зүйтэй боловч ялангуяа нөөц хязгаарлагдмал болон хүчтэй хүн амын моментум тогтсон манай улсын хувьд дээр хэлэлцсэн 3 асуудлыг маш анхааралтай авч үзэх нь чухал юм.

## **Дүгнэлт**

Хуучин социалист байсан олон улс оронд төрөлтийн бага түвшин нь нэг талаас гэр бүл дэх эдийн засгийн хязгаарлагдмал байдал ялангуяа орон сууц, бараа таваарын хомсдлын хариу үйлдэл, нөгөө талаас эмэгтэйчүүдийн боловсрол, ажиллах хүчний оролцоонд онцгой анхаарах болсны үр дүн юм. Манай улсын хувьд төрөлтийг дэмжих хүчтэй бодлогын үр дүнд хүн ам 1970-1980-аад оны үед маш эрчимтэй өссөн билээ. Гэсэн хэдий ч эдийн засгийн бэрхшээлтэй байдлаас үүдэн төрөлт буурч эхэлсэн. Бодлого боловсруулагчдын цөөнгүй хэсэг нь улс орны хүн ам зүйн өнөөгийн байдал нь эдийн засгийн хөгжлийг хангахуйц байх ёстой гэсэн өөр ойлголт, үзэл бодолтой байдаг. Улс орны эдийн засаг, нийгмийн бүтэц нь төрөлтийг нэмэгдүүлснээр хүн амын өсөлтийг бий болох хангалттай түвшинд хүртлээ хөгжөөгүй байна гэж хэлж болох юм. Хүн амын байдлыг үндсэрхэг төлөв байдлын үүднээс авч үзвэл цөөн, чадварлаг, боловсролтой, эрүүл хүн ам нь тооны хувьд олон, чанаргүй, боловсролгүй, эрүүл мэнд дорой хүн амаас илүү чухал юм.

Монголын өнөөгийн болон ирээдүйн хүн амын маргаантай асуудлууд нь улс орны эдийн засгийн салбар, мал аж ахуйн эдийн засгаас үл хамааран өнгөрсөн үеийн төрөлтийн өндөр түвшний үр дүнд хөдөлмөрийн насны хүн амын тоо олон байхад оршиж байна.

Төрөлтийг нэмэгдүүлэхэд нөөцийг дайчлахаасаа илүү хүн амын эрүүл мэндийн байдлыг сайжруулах, нас баралтыг бууруулах, ядуурлыг бууруулахад хөрөнгө оруулалт хийх нь ач холбогдолтой юм. Түүнчлэн академик болон судалгааны байгуулагууд улс орны хэмжээнд төрөлтийг нэмэгдүүлэх бодит боломж, түүний үр дагаврыг шинжлэх ухаанлаг талаас нь судлан шинжлэх шаардлагатай байна. Сэдвийн маргаан нь хийсвэр үзэл санаа дээр бус бодит баримт дээр үндэслэсэн байх хэрэгтэй.

## **Номзүй**

1. ҮСГ, 1994. Монгол Улсын хүн ам, Улаанбаатар
2. ҮСГ, 2001. 2000 оны Хүн ам Орон сууцны улсын тооллого: Үндсэн үр дүн, Улаанбаатар
3. ҮСГ, 2002. 2000 оны Хүн ам Орон сууцны улсын тооллого: Монгол Улсын хүн амын хэтийн тооцоо, Улаанбаатар
4. ҮСГ, 2003. Монгол Улсын статистикийн эмхэтгэл, Улаанбаатар
5. Bergman, B. R. 1996. Хүүхдийг ядуурлаас хамгаалах нь: АНУ Франц улсаас чухам юуг суралцаж болох вэ. Нью-Йорк, АНУ

6. Cassen, R. 1994. Хүн ам ба хөгжил: Хуучин маргаан, шинэ тохиролцоо. Нью Брунсвик, АНУ, хуудас 1-26
7. Leibenstein, H. 1957. Эдийн засгийн буурай хөгжил ба өсөлт. Нью-Йорк, АНУ
8. Monnier, A. 1990. “БНАГУ-ын гэр бүл төлөвлөлтийн бодлогын үр нөлөө: дахин-хувьсал”. Хүн ам сэтгүүл (Англи хэл дээр), эмхэтгэл 2, хуудас 127-140
9. Neupert, R. 1996. “Монгол Улсын хүн ам ба бэлчээрийн эдийн засаг” Ази-Номхон далайн бүсийн хүн амын сэтгүүл, эмхэтгэл 11, дугаар 4, хуудас 27-46
10. PRB (Хүн амын лавлах товчоо) Хүн амын гарын авлага (4 дэх хэвлэл). Вашингтон, АНУ
11. Rowland, D. T. 2003. Хүн ам зүйн ойлголт ба арга загварууд. Оксфорд, Англи
12. Serbanescu, F., L. Morris, P. Stupp, A. Stanescu. 1995. “Румын улсын үр хөндөлт ба ЖУСХ-ийн хэрэглээний талаарх одоогийн бодлогын үр нөлөө”. Гэр бүл төлөвлөлтийн судалгаа сэтгүүл, эмхэтгэл 26, хуудас 76-87.
13. Van de Kaa, D. 1987. “Европын улс орнуудын хоёр дахь хүн амын зүйн шилжилт”. Хүн амын эмхэтгэл. эмхэтгэл 42, дугаар 1, хуудас 1-57
14. Weeks, J. 2002. Хүн ам. Ойлголт ба Асуудлууд. (8 дахь хэвлэл) Белмонт, АНУ